



Монголын Хөдөлмөрийн
Эрүүл Ахуйчдын Үндэсний
Холбоо

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ MNAOH P-03

Боловсруулсан:

Мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйчдын зөвлөл

2024.03.27

Баталгаажуулж, хэрэглэх зөвшөөрөл олгосон:

Холбооны удирдах зөвлөл

2023.04.01

Баримт бичигт өөрчлөлт хийсэн бүртгэл

<u>Хувилбар</u>	<u>Огноо</u>	<u>Өөрчлөлт хийсэн тэмдэглэл</u>	<u>Өөрчлөлт хийсэн:</u>
V1	2024.04.01	Шинээр боловсруулсан.	Д.Нарансүх

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү Ёс зүйн дүрэм (цаашид “дүрэм” гэнэ) нь Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо (цаашид “холбоо” гэнэ)-ны гишүүд мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн болон мэргэжлийн чадамжийн хэм хэмжээг тогтооно.

1.2 Энэхүү дүрмийг холбооны бүх гишүүн цалинтай (төлбөртэй) болон сайн дураараа хийж буй аливаа мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3 Холбооны гишүүд энэхүү дүрмийг үйлчлүүлэгч, ажил олгогч, ажилтан, төрийн байгууллага, хувийн хэвшил, олон нийттэй харилцах хэм хэмжээний удирдамж болгож мөрдөнө. Түүнчлэн холбооны гишүүдийн зан харилцааны байдлыг үнэлж дүгнэхэд энэхүү дүрмийг шалгуур болгон ашиглана.

1.4 Энэхүү дүрмийг мөрдөхтэй холбоотойгоор гишүүдээс аливаа хууль тогтоомжид харш үйлдэл гаргахыг шаардахгүй.

1.5 Энэхүү дүрэм нь ёс зүйн зөрчил, маргаан, дарамт шахалтад өртсөн холбооны гишүүдийн асуудлыг шударгаар шийдвэрлэхэд удирдамж болно.

1.6 Энэхүү дүрэм дараах агуулгатайгаар холбогдох нэршлүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- **Гишүүн** гэж холбооны журамд заасан гишүүнчлэлийн зэрэгтэй аливаа гишүүн, мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйч;
- **Практикт нийцсэн** гэдэг нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийн шаардлагыг хангасан, бодит амьдрал хэрэгжүүлэх боломжтой практик үйл ажиллагаа;
- **Үйлчлүүлэгч** гэдэг нь холбооны гишүүнээс хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн үйлчилгээг зохих цалин хөлс, төлбөртэйгээр авч буй ажил олгогч эсвэл хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага;
- **Ажилтан:** Холбооны гишүүний мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж буй ажлын байранд ажил хөдөлмөр эрхэлж буй хүн;
- **Ажил олгогч:** Холбооны гишүүнээс мэргэжлийн тусламж үйлчилгээ авч буй бизнес, ажлын байрыг хариуцсан хуулийн этгээд эсвэл хувь хүн;
- **Шинжлэх ухаанч нотолгоо.** Мэргэжлийн хүрээнийхэнд хүлээн зөвшөөрөгдсөн онолын үндэслэлтэй, шинжлэх ухаанч судалгаагаар нотлогдсон баримт;
- **Сайн туршлага:** Олон улс, үндэсний түвшинд практикт нийцсэн байдал, үр нөлөө нь туршигдаж баталгаажсан практик;

Хоёр. Гишүүний үүрэг хариуцлага

2.1 Холбооны гишүүний үндсэн үүрэг нь үйлчлүүлэгч, ажил олгогч, ажилтны үйл ажиллагаанаас шалтгаалан ажилтан, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон сайн сайхан байдалд нөлөөлж болзошгүй аюулыг урьдчилан таамаглах, таньж илрүүлэх, эрсдэлийг нь тодорхойлох, тохиромжтой арга хэлбэрээр холбогдох талд мэдээлж харилцах, эрсдэлээс сэргийлэх, бууруулах зэрэг дараах арга хэмжээг зөвлөнө.

2.2 Холбооны гишүүн энэхүү үүргээ аливаа арилжааны болон хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж хэрэгжүүлэх ба дараах зарчмыг баримтална:

- 1) Ажил олгогч, үйлчлүүлэгч, ажилтанд эрүүл мэндэд эрсдэлгүй хөдөлмөрийн нөхцөлийг практикт нийцүүлэн бий болгож, хадгалахыг зөвлөх;
- 2) Ажил олгогч, үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагааны нууцлал бүхий мэдээллийг хамгаалах, бусдад дамжуулахгүй байх;
- 3) Ажил олгогч, үйлчлүүлэгч, олон нийтэд хууль тогтоомж, мэргэжлийн стандартын шаардлагыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтан, тэдний төлөөлөлд

- хуулиар олгогдох эрхийнх нь дагуу холбогдох мэдээллийг өгөх, зөвлөх;
- 4) Хөдөлмөрийн эрүүл ахуйн эрх бүхий байгууллагаас шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцсэн хэмжилт үнэлгээний аргачлал, хэмжилтийн багаж хэрэгслийг ашиглах, итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ, шалгалт тохируулга хийлгэх замаар хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээг хэрэгжүүлэх;
 - 5) Хэмжилт, үнэлгээний үр дүнг нотолгоонд суурилан ойлгомжтой байдлаар илэрхийлж, зөвхөн үйлчлүүлэгчдээ мэдээлэх, зөвшөөрөлгүйгээр мэдээллийг бусдад дамжуулахгүй байх;
 - 6) Санамсаргүй тохиолдлоор үйлчлүүлэгчийнхээ мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулсан байж магадгүй тохиолдолд тухайн үйлчлүүлэгчдээ мэдээлэх, шаардлагатай бол холбооноос зөвлөгөө авах;

Гурав. Баримтлах зарчим, мэргэжлийн чадамж

3.1 Холбооны гишүүн нь мэргэжлийн ажлаа эрхлэхдээ дараах зарчмыг баримтлана.

- 1) Мэргэжлийн ажилдаа ямар ч үед **зарчимч, мэргэжлийн, хариуцлагатай** хандана.
- 2) Асуудалд **үнэн бодитоор хандаж, шударгаар** ажиллана.
- 3) Хуулиар хүлээсэн үүргээ **шударгаар** биелүүлнэ.
- 4) Өөрийн удирддаг мэргэжлийн үйл ажиллагааг **чадварлаг гүйцэтгэж, үнэн бодитой тайлагнаж** буйд хяналт тавина.
- 5) Эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй орчны хүчин зүйлсийг урьдчилан таамаглах, таньж илрүүлэх, хэмжиж үнэлэх, хяналт тавьж бууруулахад **мэргэжлийн байр сууринаас хандана**.
- 6) Хэмжилт үнэлгээ, ажиглалтын үр дүн, дүгнэлтийг **практикт нийцсэн** байдлаар үнэн зөв, ойлгомжтой тодорхой мэдээлнэ.

3.2 Холбооны гишүүн мэргэжлийн чадамжийг хангалттай түвшинд хадгалж, хөгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана.

- 1) Шаардлага хангасан зохих мэргэжлийн сургалтанд хамрагдаж, ур чадвараа тогтмол хөгжүүлнэ.
- 2) Мэргэжлийн зөвлөмж, тайлбарыг тухайн цаг үеийн шинжлэх ухааны баримт нотолгоонд үндэслэн боловсруулна.
- 3) Мэргэшиж суралцсан, чадамж эзэмшиж, туршлага хуримтлуулсан чиглэлээрээ дүгнэлт, шүүмжийг шинжлэх ухаанч мэдлэг, нотолгоонд үндэслэн хийж, ойлгомжтой тодорхой, үнэн бодитойгоор тайлагнана.
- 4) Энэхүү дүрмийг зөрчихгүйгээр өөрийн мэргэшсэн мэргэжлийн мэдлэгээ нийтэд мэдэгдэж, чадамжаа нийтэд зарлаж болно.

Дөрөв. Ашиг сонирхлын зөрчил

4.1 Холбооны гишүүн нь тайлан дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргахад үйлчлүүлэгч талыг танимхайрах, санхүүгийн болон хувийн ашиг сонирхлын харилцааны илэрхий зөрчил үүсгэхээс зайлсхийж сэргийлнэ.

4.2 Холбооны гишүүн мэргэжлийн ажлаа эрхлэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэх аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд зохих талд мэдэгдэнэ.

4.3 Бусад гишүүн ашиг сонирхолын зөрчилд өртсөн бодит эсвэл болзошгүй тохиолдлын талаар мэдсэн бол зохих газар нь үнэн зөв, шуурхай мэдээлнэ.

4.4 Холбоо нь гишүүдийнхээ ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй мэдээллийг хүлээн авч бүртгэж, хянан шийдвэрлэнэ.

Тав. Нууцлалыг чандлан хадгалах

5.1 Холбооны гишүүн нь олж мэдсэн аливаа мэдээлэл, баримт бичгийг зөвхөн ажилтны эрүүл мэнд, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлагыг хангахад ашиглана.

5.2 Ажлын явцад олж авсан мэдээллийн нууцлалыг хадгална. Тухайн мэдээллийг хамаарах байгууллага эсвэл хувь хүний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно. Бусдад мэдээлэл дамжуулах нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох тал, хууль ёсны төлөөлөгчөөс бичгээр зохих зөвшөөрлийг авсан байна.

5.3 Байгууллага, хувь хүний нууцийг хамгаалах хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрдөнө.

Зургаа. Мэдээллийг ил болгох, шүгэл үлээх

6.1 Ажил олгогч, байгууллага хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хууль тогтоомж, стандартыг зөрчсөний улмаас ажилтанд бэртэл гэмтэл, өвчин үүсгэх нөхцөл бий болсныг холбооны гишүүн мэдсэн бол тэр даруй зохих хариу арга хэмжээ авна.

6.3 Ноцтой эрсдэл үүссэн нөхцөлд холбооны бусад эрүүл ахуйн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж болох ба ёс зүйн үүргийнхээ дагуу болзошгүй эрсдэлийг арилгах бууруулах үүрэгтэй ажил олгогч, байгууллагад мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэл хийсэн гишүүнийг "шүгэл үлээгч" гэж үзэж зохих хуулийн дагуу эрхээ хамгаалахад нь холбооны зүгээс дэмжлэг үзүүлнэ.

6.4 Хэрэв ажил олгогч, байгууллагын зүгээс ажилтныхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авахгүй бол эрсдэлийг бууруулах, арилгах зорилгоор гуравдагч тал (эрх бүхий төрийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн ХАБЭМ-ийн төлөөлөгч г.м)-д энэ мэдээллийг задруулна.

6.5 Холбооны гишүүн энэхүү дүрмийн дагуу ёс зүйн үүргээ биелүүлээгүйг аль нэг гишүүн мэдсэн бол холбоонд энэ талаар мэдээлнэ.

Долоо. Мэргэжлийн нэр хүнд, байр сууриа хамгаалах

7.1 Бүх гишүүд холбооны үйл ажиллагаанд оролцох, өөрийн мэргэжлийн ажлаа хийхдээ ёс зүйн дүрмийг мөрдөх, мэргэжлийнхээ нэр хүндийг өндөрт өргөх, мэргэжлийн байр сууриа хамгаалах, сурталчлах, дэмжих зарчмыг ямагт баримтлана.

7.2 Холбооны гишүүн нь хөдөлмөрийн эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн мэргэжилтний хувьд дараах байр суурийг баримтлана. Үүнд:

- 1) Хөдөлмөрийн эрүүл ахуйн зөвлөгөө тайлбарыг зөвхөн мэргэжлийн үүднээс хийнэ.
- 2) Мэргэжлийн нэр хүндийг гутаан доромжлох, мушгин гуйвуулах, олон нийт, холбоо болон төрийн байгууллагыг хууран мэхлэх аливаа үйлдлээс зайлсхийнэ.
- 3) Бусад гишүүний мэргэжлийн нэр хүндэд халдах, хариуцлагагүй үйлдлийн улмаас хохирол учруулахаас зайлсхийж, мэргэжлийн ур чадвар, туршлагыг нь хүндэтгэн, хүлээн зөвшөөрнө.
- 4) Холбооны байр суурийг буруугаар тайлбарлах, мушгин гуйвуулах аливаа үг яриа, тайлбар, үйлдэл хийхгүй.
- 5) Хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг зүй бусаар ашиглахгүй байх;

Найм. Үйлчлүүлэгчийнхээ өмнө хүлээх хариуцлага

8.1 Холбооны гишүүд нь үйлчилгээ, зөвлөгөө авч буй үйлчлүүлэгч, ажил олгогч, байгууллагатай харилцахдаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- 1) Ёс зүйтэй харилцах;
- 2) Санхүүгийн эсвэл материаллаг өдөөлтийг санал болгохгүй байх;

- 3) Өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл ажиллагаанд нь эрсдэл үүсгэх, хараат бус байдлыг алдагдлуулах, мэргэжлийн итгэл үнэмшлээрээ шийдвэр гаргахад нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын талаар хэлж зөвлөх;
- 4) Үйлдсэн бүх баримт бичиг, тайландаа өөрийн мэргэжлийн ур чадамжийг үнэн зөвөөр илэрхийлэх;
- 5) Хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүн, гүйцэтгэлийг үйлчлүүлэгч, ажил олгогчид хариуцлагатай, зохих ёсоор нь тодорхой ойлгомжтойгоор мэдээлэх;
- 6) Практикт нийцсэн аргачлалын дагуу бэртэл гэмтэл, өвчин эмгэг үүсгэх эрсдэлийг таньж тогтоож, тэдгээр эрсдэлийг хянаж бууруулах үүрэг бүхий талд тодорхой мэдээлэх;
- 7) Өөрийн ажиллаж буй салбартаа мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ тогтмол хөгжүүлж, мэргэжлийн ур чадамжаа хадгалах;
- 8) Мэргэжил эзэмшилт, мэдлэг, чадамжийн түвшингөө худал мэдүүлэхгүй байх эсвэл хэн нэг этгээд уг мэдээллийг худал, буруу ташаа түгээх боломжийг олгохгүй байх,
- 9) Ажилтан, олон нийтийн эрүүл мэндийн эрсдэлтэй холбоотой аливаа мэдээллийн талаар мэдэгдэл тайлбар хийхдээ зөвхөн өөрийн мэргэшсэн чиглэлээр шинжлэх ухааны хангалттай баримт нотолгоонд үндэслэн хийх;
- 10) Мэргэжлийн ажлаа хараат бус байдлаар гүйцэтгэх, мэргэжлийн итгэл үнэмшлээр гаргах шийдвэрт эрсдэл учруулах үйлдлийн талаар үйлчлүүлэгч, ажил олгогчид мэдээлэх;
- 11) Мэргэжлийн үйлчилгээг явуулахдаа холбогдох талуудаас зөвшөөрөл аваагүй бол зөвхөн нэг талын үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлнэ. Тухайлбал нэг үйлчлүүлэгчтэй хийсэн гэрээгээр эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж буй бол үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр уг ажил дээр бусад талтай хамтран ажиллаж болохгүй.

Ес. Хариуцлага ба гомдол, маргаан шийдвэрлэх

9.1 Холбооны гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх гомдол, маргааныг энэхүү дүрэм болон холбооны бусад журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

9.2 Холбооны дүрэм, журмыг зөрчих, үйл ажиллагааны эсрэг үйлдэл, зан харилцаа гаргах нь ёс зүйн зөрчилд тооцогдоно. Энэ талаарх мэдээлэл, санал гомдлыг Холбооны Удирдах Зөвлөл хүлээж авч шийдвэрлэнэ.

9.3 Холбооны Удирдах Зөвлөл ёс зүйн зөрчлийн тохиолдлыг хянан үзэж, үндэслэлтэй нь тогтоогдвол тухайн гишүүнд сануулга өгөх, холбооны гишүүнчлэлээс хасах, олон нийтэд мэдээлэх зэрэг сахилгын арга хэмжээ авч болно.

9.4 Энэхүү Ёс зүйн дүрмийг зөрчсөн тухай гомдол, маргаан, санал гомдлыг Холбооны Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргад mnaohmn@gmail.com имэйлээр илгээнэ үү.

Төгсөв.